

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

**МУОНТ-ИЙН “МОНГОЛЫН МЭДЭЭ” АГЕНТЛАГИЙН МЭДЭЭ,
МЭДЭЭЛЛИЙН ХӨТӨЛБӨРТ ХИЙСЭН АЖИГЛАЛТ**

Г.Мэндхүү*

*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор

Түлхүүр үг:МУОНТ, мэдээллийн хөтөлбөр, оргил цаг, ММ агентлаг, Цагийн хүрд, титр, субтитр

Манай улсын ууган телевиз тавин жилийн түүхтэй. Түүхэндээ гурван удаа нэрээ сольж байсан (Монгол телевиз, Монголын Үндэсний телевиз, Монголын үндэсний олон нийтийн телевиз) тус телевизийн мэдээ, мэдээллийн хөтөлбөрийг “Монголын мэдээ” агентлаг хариуцан бэлтгэдэг.

Мэдээллийн хөтөлбөр (news program) гэдэг бол цаг хугацааны тодорхой хүрээнд (эсвэл яг энэ цаг мөчид) өрнөж байгаа анхаарал татсан үйл явдал, үзэгдлийн талаар мэдээлдэг, тогтмол цагт шинэ дугаар нь хүлээн авагчдад (сонсогч, үзэгч) хүрдэг нэвтрүүлгийн хэлбэр юм. Улс төр, эдийн засаг, боловсрол, аж ахуй, урлаг, спортын салбарт өрнөсөн (өрнөж байгаа) нийгмийн ач холбогдол ихтэй, нийт ард түмний анхаарлыг татахаар үйл явдлыг сэтгүүл зүйн мэдээллийн бичлэгийн төрөлд харьяалагддаг мэдээ, сурвалжлага, ярилцлага, тайлан, тойм гэх мэт зүйлээр

туурвисан сэтгүүлчийн бүтээлийг мэдээллийн хөтөлбөрөөр үзүүлдэг. Ингэхдээ мэдээ, сурвалжлагыг нийгмийн ач холбогдол, цар хүрээгээр нь эрэмбэлж тодорхой дарааллын дагуу хүлээн авагчдад дамжуулдаг.

Телевизийн мэдээллийн хөтөлбөрийн талаар бусад судлаачид ч өөр өөрсдийн тодорхойлолтыг гаргасан байна. “Мэдээллийн хөтөлбөр бол ямагт нийгмийн эрх ашгийг илэрхийлж, тухайн нийгмийн байгууллага төгс төгөлдөр болгоход дэм болох ёстой. Нэг ёсондоо мэдээллийн хөтөлбөр бол бүх нийтийн сайн сайхны төлөө хөтөлбөр юм.”¹ гэж Оросын сэтгүүл зүй судлаач В.Л.Цвик тодорхойлжээ. Харин судлаач Х.Наранжаргал “Улс орны, дэлхийн хэмжээний үйл явдал, үзэгдэл, улс төр, эдийн засаг, нийгмийн асуудлаар бэлтгэсэн мэдээ, мэдээний хөтөлбөрийг энд хамруулна.”² хэмээн тодорхойлжээ.

Тухайн өдрийн “дүр зургийг” л мэдээллийн хөтөлбөр үзэгчдэд харуулах нь эрхэм зорилго нь гэж баттай хэлж болно. Гэхдээ тухайн өдөр болсон бүх үйл явдал, үзэгдлийг мэдээллийн хөтөлбөрт мэдээ, сур-

валжлага хэлбэрээр мэдээлэх боломжгүй. Шалтгаан нь амьдралд тохиолдлын шинжтэй, нийгмийн ач холбогдол бага үйл явдал ч олон тохиолддог. Иймээс мэдээллийн хөтөлбөрт юуг мэдээлэх вэ? гэдэг нь бодолцох ёстой асуудал юм. Телевизийн өмчийн харьяалал нь төрийн, олон нийтийн, арилжааны гэдгээс үл хамаарч эфирээр үзүүлж байгаа мэдээллийн хөтөлбөр нь үргэлж нийгмийн ач холбогдолтой асуудлыг хөндсөн, хүн амын бүх давхаргад чиглэгдсэн байдаг. Ер нь телевизийн мэдээллийн хөтөлбөр бол олон нийтийн ашиг сонирхлыг эрхэмлэж байх, олон ургалч үзлийн индэр байж, тэнцвэртэй мэдээлэл хүргэж байх ёстой юм.

Мэдээллийн хөтөлбөрийг телевизээр үзүүлэх цаг тогтмол байх нь улс төрийн, нийгэмсэтгэл зүйн ач холбогдолтой. Мэдээллийн хөтөлбөрийг өдөр бүр тодорхой тогтсон цагт үзүүлж байвал улс орны байдал хэвийн тогтвортой байна гэж үзэгч төсөөлдөг. Нэвтрүүлгийн сүлжээнд тогтмол байр суурь эзэлсэн, үзэгчдийн дуртай нэвтрүүлгийн эфирт гаргах хугацааг 5-10 минут, магадгүй түүнээс ч илүү хугацаагаар хөдөлгөх нь хэвийн үзэгдэл. Харин мэдээллийн хөтөлбөр тогтсон цагтаа гарахгүй бол, эсвэл өөр цагаар гэнэт гарвал үзэгчдэд гайхшрал, үл ойлгогдох байдал үүсгэнэ. Улс оронд онцгой байдал зарласан юм биш биз?, Ямар нэгэн ноцтой үйл явдал болсон учраас шуурхай мэдээ дамжуулж байгаа юм болов уу? гэсэн түгшүүр, хардлага төрүүлж болзошгүй. Дэлхийн жишгээс харвал АНУ-ын “CNN”, “FOX NEWS”, Их Британийн “BBC WORLD”, ОХУ-ын “Russia Today”, манай улсын “Eagle news” гэх мэт мэдээний төрөлжсөн телевизийн сувгууд цаг тутмын эхэнд

мэдээллийн хөтөлбөр үзүүлдэг. Тэгвэл БНХАУ-ын төв телевизийн нэгдүгээр суваг (“CCTV-1”), ОХУ-ын “Россия”, “Первый канал”, “НТВ”, Японы “NHK”, БНСУ-ын “KBS-1”, мөн манай улсын “UBS-1”, “TV9”, “25 дугаар суваг” телевизээр 3-4 цаг тутамд нэг удаа мэдээллийн хөтөлбөр үзүүлдэг нэвтрүүлгийн сүлжээ зохиосон байна. Манай улсын хувьд ихэнх телевизийн сувгууд оройны оргил цагаар мэдээллийн хөтөлбөр үзүүлдэг. Судлаач Т.Өнөрсайхан “Монголын телевизүүд 19:00-22:00 цагийн эфирийг хамгийн их үзэгчтэй буюу оргил цаг гэж тооцдог³” хэмээн судалгааны бүтээлдээ дурдсан байдаг. Мэдээллийн хөтөлбөр бол тухайн телевизийнхээ “нэрийн хуудас” нь болдог гол төлөв оргил цагаар эфирт гардаг чухал нэвтрүүлэг билээ.

1967 оны 9 дүгээр сарын 27-ний өдрөөс эхлэн тогтмол нэвтрүүлэг дамжуулж эхэлсэн Монголын үндэсний олон нийтийн телевиз (хуучин нэрээр Монгол Телевиз) эфирээ эхлэхдээ мэдээ танилцуулдаг байв. Мөн орой хөтөлбөрийн төгсгөлдөө мэдээ танилцуулахдаа өмнөх мэдээгээ давтах, зарим тохиолдолд шинэ баримтаар баяжуулж нэвтрүүлдэг байжээ. 1997 онд Монгол телевизийн 30 жилийн ойд зориулан сэтгүүлч, зохиолч Д.Дожоодоржийн эмхтгэн гаргасан “Зурагт зулын хойморт заларсан нь” номд энэ тухай цохон тэмдэглэсэн байдаг. 1968 онд Монгол телевизийн нэвтрүүлгийн дараалалд ажиглалт хийхэд мэдээллийн нэвтрүүлэг тухайн өдрийн эфирийн цагийн 10 хувийг эзэлж байжээ. 1967-1972 он хүртэл Монгол телевизийн мэдээний нэвтрүүлэг “Мэдээ” нэрээр гарч байв⁴. Тухайн үед “Монгол Телевиз”-ийн нэвтрүүлгийн сүлжээг зохиоходоо ЗХУ, Польш, Чехословак (хуучин нэрээр), Болгар, Югослав

(хуучин нэрээр) гэх мэт тухайн үеийн социалист орнуудын телевизийн жишгийг дагажээ. 1967 оны дөрөвдүгээр улиралд хийх нэвтрүүлгийн сар бүрийн 1,2,3,4 дэх долоо хоногт мэдээллийн редакци 18 минут, суртал нэвтрүүлгийн редакци 30 минут, хүүхэд залуучуудын редакци 22 минут, хөгжмийн нэвтрүүлгийн редакци 25 минут, урлаг соёлын редакци 18 минут, кино программын редакци 2 цаг 10 минут гэх мэтээр цаг авч, сүлжээ бүрдүүлсэн байна⁵. Оросын сэтгүүлч Юрий Летуновын санаачилгаар ЗХУ-ын “Төв телевиз” 1968 оны нэгдүгээр сарын 1 өдрөөс эхлэн “Время” (Цаг үе) мэдээллийн хөтөлбөрийг бэлтгэн үзүүлдэг болжээ. Энэ мэдээллийн хөтөлбөр анх бий болсон цагаас эхлэн өнөөдрийг хүртэл мөрдөгдөж байгаа мэдээ хүргэх дараалал төлөвшжээ. Эхлээд төрийн өндөрлөгүүдийн ажлын тухай протоколын мэдээ, дараа нь эдийн засаг, аж үйлдвэрийн салбар, соёл урлаг, спорт, цаг агаарын мэдээ гэсэн дараалал байв.

1973 оноос “Монгол телевиз”-ийн уран бүтээлчид энэ жишгийг даган мэдээллийн хөтөлбөр бэлтгэхээр болжээ. Ийнхүү “Цаг үе” мэдээллийн хөтөлбөр “Монгол телевиз”-ийн эфирээр гардаг болов. 1975 оны есдүгээр сарын 30-наас эхлэн “Монгол телевиз”-ийн программын захиргааны даргаар ажиллаж байсан Ц.Нацагдоржийн удирдлага доор “Цаг үе, үйл явдал” мэдээллийн хөтөлбөрийг бэлтгэх болж ярилцлага, сурвалжлага, тайлбар, тойм багтаажээ. “Монгол телевиз” анх өөрийн гэсэн тоймчгүй байсан тул “МОНЦАМЭ” агентлагийн тоймч нар дэлхийн болон Монголын улс төр, нийгмийн асуудлаар ярьдаг байжээ.⁶ “Цаг үе, үйл явдал” нэвтрүүлгийг санаачлагчид нь “Цагийн хүрд” гэж

нэрлэснийг нь МАХН-ын Төв Хорооны үзэл суртлын хэлтэс батлаагүй тухай түүхийг судлаач Х.Наранжаргал “Телевизийн сэтгүүл зүй: үндсэн ойлголт, зөвлөмж” гарын авлагадаа цохон тэмдэглэжээ. Монголд мэдээллийн хөтөлбөрийг хөгжүүлэх, төлөвшүүлэхэд олон сурвалжлагч, редактор хувь нэмэр оруулснаас хариуцлагатай редактор байсан П.Банзрагч, С.Батмөнх, Д.Батболд, сурвалжлагч Д.Чулуунбаатар, Г.Басдолгор, С.Алтанцэцэг, Д.Сарангэрэл, Ц.Сүхбаатар, Ц.Мөнхтөр, С.Мөнхцэрэн, М.Банзрагч, нарыг онцлон тэмдэглэмээр байна. Ялангуяа Ц.Мөнхтөр, С.Мөнхцэрэн нарыг “Монгол Телевиз”-ийн анхны тоймч, тайлбарлагч гэхэд хилсдэхгүй.⁷

“Монгол Телевиз”-ийн 1969 оноос эхлэн “Показывает Улан-Батор” (“Улаанбаатар үзүүлж байна”) нэвтрүүлгийг орос хэлээр бэлтгэж байсан. Тус нэвтрүүлгээр БНМАУ-ын нам төрийн шийдвэр, Монгол орны нийгэм, аж амьдралын тухай мэдээ, сурвалжлага үзүүлдэг байжээ. Энэ нэвтрүүлэг нь Монголд ажиллаж, амьдарч байгаа Зөвлөлтийн мэргэжилтнүүд, орос хэл судалж байгаа монголчуудад зориулагдсан байв. Одоо 2017 оны өндөрлөгөөс харахад “Показывает Улан-Батор” нь Монгол орныг социалист орнуудад танилцуулах, сурталчлахад эерэг нөлөө үзүүлсэн сайн мэдээллийн хөтөлбөр байжээ гэж дүгнэж болохоор байна.

1993 оны гуравдугаар сарын 23-нд “Монгол телевиз”-ийн мэдээний албаны нэрийг өөрчилж “ТВМ” мэдээллийн агентлаг гэх болжээ. Үүнтэй зэрэгцэн “Цаг үе, үйл явдал” мэдээллийн хөтөлбөрийн нэрийг өөрчилж “Цагийн хүрд” гэдэг нэрийг өгчээ. “Цаг

үе үйл явдал” гэсэн албархаг нэрээс татгалзаж, монгол хүний сэтгэлгээнд нийцсэн, гүн ухааны гүнзгий давхар утга агуулсан “Цагийн хүрд” гэсэн нэрийг оноож өгчээ. “ТВМ” агентлагийн нэрийг 1996 онд өөрчилж “Монголын мэдээ” (ММ) агентлаг гэх болжээ. Шинээр байгуулагдсан энэ агентлагийн анхны захиралаар сэтгүүлч Г.Бадамсамбуу томилогджээ. “1996 оны сонгуулийн дараа би “ММ” агентлагт ирсэн. “ММ” агентлагийг хэнээс ч хараат бус, бие даасан статустай байх ёстой гэж их ч юм хийсэн, тэмцсэн. Намайг “ММ” агентлагийн “Загалмайлсан эцэг” гэж одоо ч дурсах хүн олон бий”⁸ хэмээн сэтгүүлч Г.Бадамсамбуу дурсан ярьжээ. “ММ” агентлагийг анх байгуулагдахад Д.Сарангэрэл, Б.Сарантуяа, Д.Цондовдорж, Ц.Сүх-баатар, С.Мөнхцэрэн, Д.Энхтайван, Ц.Оюундарь нарын сэтгүүлчид ажиллаж байв. 1996 онд “ММ” агентлаг анх байгуулагдахад лого шаардлагатай болжээ. Хоёр М үсэг нийлээд үелзэл долгион үүсгэсэн энэ логоны эх санааг сэтгүүлч Г.Бадамсамбуу, Л.Цагаан-далай, Д.Цондовдорж, Ц.Оюундарь нар ярилцаж

байгаад гаргасан. Логоны зургийг дизайнер Ш.Цогтсайхан зуржээ.

Судлаач Л.Норовсүрэн, Н.Ариунзаяа нар “Телевизийн сэтгүүл зүй” сурах бичигтээ “1996 онд Япон улсаас цаас харалгүй уншигч төхөөрөмж авч ашигласнаар нэвтрүүлэгч нар үзэгчид рүү шууд хандан ярьж, мэдээллийн итгүүлэх чадварыг нэмэгдүүлж чадсан байна. Мөн онд “ТВМ” агентлагийг өргөтгөн “ММ” агентлаг болгож, радио телевизийн техник төхөөрөмжийг тус тусын салбарт нь шилжүүлэн өгөх, МРТХЭГ-ын харьяанд Радио телевизийн дээд сургууль байгуулах зэргээр бүтэц, зохион байгуулалтын зоригтой алхам хийжээ”⁹ гэж цохон тэмдэглэсэн байдаг.

Хэдийгээр агентлаг гэдэг үгийг хэрэглэсэн боловч үйл ажиллагааны цар хүрээ нь “МОНЦАМЭ”, “ИТАР-ТАСС”, “РИА-Новости”, “Шинхуа”, “Киодо-Цусин”,

“Ассошэйтед-Пресс”, “Франс-Пресс” гэх мэт мэдээллийн агентлагийн төвшинд хүрдэггүй. Мэдээллийн агентлаг бол улс орныхоо бүх бүс нутаг төдийгүй дэлхийн олон оронд өөрийн сурвалжлагчаа байнга суурин ажиллуулдаг. Сурвалжлагч нарынхаа бэлтгэсэн

«

Мэдээллийн агентлаг бол улс орныхоо бүх бүс нутаг төдийгүй дэлхийн олон оронд өөрийн сурвалжлагчаа байнга суурин ажиллуулдаг. Сурвалжлагч нарынхаа бэлтгэсэн мэдээ, сурвалжлага, тайлан, тойм, сурвалжилсан тэмдэглэл зэргийг өөрийн орны, мөн харь орны хэвлэл мэдээллийн байгууллагад тодорхой нөхцөлтэйгөөр худалддаг. Гадаад улсын мэдээллийн агентлагтай хамтран ажиллах гэрээ байгуулж “мэдээллийн бүтээгдэхүүн” солилцдог. Мөн улсынхаа Засгийн Газрын дотоод хэрэгцээнд зориулан мэдээлэл бэлтгэж өгдөг. Харин “ММ” зөвхөн Монголын ууган телевизийн мэдээллийн хөтөлбөрт зориулж мэдээ, сурвалжлага бэлтгэхээс хэтэрдэггүй. Иймд агентлаг гэдэг үг ахадсан ч байж мэднэ

»

мэдээ, сурвалжлага, тайлан, тойм, сурвалжилсан тэмдэглэл зэргийг өөрийн орны, мөн харь орны хэвлэл мэдээллийн байгууллагад тодорхой нөхцөлтэйгөөр худалддаг. Гадаад улсын мэдээллийн агентлагтай хамтран ажиллах гэрээ байгуулж “мэдээллийн бүтээгдэхүүн” солилцдог. Мөн улсынхаа Засгийн Газрын дотоод хэрэгцээнд зориулан мэдээлэл бэлтгэж өгдөг. Харин “ММ” зөвхөн Монголын ууган телевизийн мэдээллийн хөтөлбөрт зориулж мэдээ, сурвалжлага бэлтгэхээс хэтэрдэггүй. Иймд агентлаг гэдэг үг ахадсан ч байж мэднэ.

2000 оноос хойш тус телевизээр “ММ today” мэдээллийн хөтөлбөрийг англи хэлээр үзүүлж байна. “ММ” агентлагийн сурвалжлагч нарын бэлтгэсэн мэдээ, сурвалжлагыг англи хэлнээ орчуулан өдөр бүр 10 минутын мэдээллийн хөтөлбөр бэлтгэж байгаа нь цаг үеийнхээ эрэлт, хэрэгцээ шаардлагад нийцсэн алхам болсон юм. Мөн 2000 оноос “Монголын Үндэсний Телевиз” өглөөний эфиртээ өмнөх өдрийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрийг давтан үзүүлдэг болов. Даваа-баасан гарагт өглөө 8:00-9:00 цагт, бямба ням гарагт 7:30-8:30 цагт давталтыг нь нэвтрүүлж байлаа. 2005 оны эхээр Монгол Улсын парламент “Олон Нийтийн Радио, Телевизийн тухай хууль” баталсан. Энэ хууль 2005 оны долдугаар сарын нэгний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Хуулийн дагуу тус телевиз нь нийгмийн бүх бүлэг, давхаргад зориулсан, үндэсний урлаг, ёс заншил, хэл соёлыг сурталчилсан нэвтрүүлэг бэлтгэх үүрэг хүлээх болсон. Олон нийтийн гэсэн тодотголтой болмогцоо “ММ” агентлаг монгол хэлний буриад аялгуу, мөн казах, тува хэлээр мэдээллийн хөтөлбөр бэлтгэн үзүүлдэг болов. “ММ”

агентлагийн сурвалжлагч нарын монгол хэлээр бэлтгэсэн мэдээг орчуулан үндэсний цөөнхөд зориулан нэвтрүүлдэг болсон.

2015 оны сүүлээр “Монголын үндэсний олон нийтийн телевиз”-ийн мэдээллийн хөтөлбөрийг хариуцдаг “ММ” агентлагийг “Олон Нийтийн Радио”-гийн мэдээ, мэдээллийн хөтөлбөрийг хариуцан бэлтгэдэг “Хурд” агентлагтай нэгтэв. Ингэснээр радиогийн сурвалжлагч бэлтгэсэн мэдээгээ радиогоор дамжуулахаас гадна телевизийн хувилбараар бэлтгэж цэнхэр дэлгэцээр хүргэх, телевизийн сурвалжлагч нь бэлтгэсэн мэдээгээ радиогийн долгионоор дамжуулах болсон юм. Жишээ нь, “Монголын Үндэсний Радио”-гийн “Хурд” агентлагийн гадаад мэдээний хэлтэст ажиллаж байсан орчуулагч-редактор Т.Цогтоо “Монголын Үндэсний Телевиз”-ийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрөөр гадаад мэдээний тойм хийж, “ММ” агентлагийн гадаад мэдээний хэлтэсийнхэн чадварлаг тоймчтой болжээ.

Радиод мэдээллийг дуу чимээ, үгээр мэдээлэл дамжуулдаг. Харин телевизэд дуу чимээ, үгээр мэдээлэл дамжуулахаас гадна тохирох дүрс, зурагтай нь хослуулах нь чухал. Радио, телевизийн аль алин нь өөр өөрийн гэсэн онцлогтой. “Хурд” агентлагийг “ММ” агентлагтай нэгтгэсэн нь тийм ч оновчтой алхам биш гэж судлаачийн хувьд үзэж байна. Үүний үр дагавар нь дорхноо анзаарагдсан. “Монголын үндэсний олон нийтийн радио”-гийн цаг тутмын мэдээ, мэдээллийн хөтөлбөрийн чанар эрс дордсон.

2016 оны нэгдүгээр сарын 11-ний өдөр МҮОНТ хоёрдугаар суваг нээв. Ингэснээр тус телевизийн мэдээллийн алба нь тусдаа сувагтай болов. “Монголын мэдээ” сувгаар

өглөөнөөс үдэш хүртэл мэдээ, сурвалжлага, ярилцлага үзүүлж байна. Тухайн үед МҮОНРТ-ийн эрх барих дээд байгууллага “Үндэсний Зөвлөл” нь МNB(олон нийтийн телевизийн нэгдүгээр суваг) сувгаар хүүхдийн нэвтрүүлэг, урлаг спорт, танин мэдэхүйн нэвтрүүлэг, уран сайхны кино л үзүүлнэ. Улс төр, нийгэм, эдийн засгийн тухай мэдээлэл дамжуулах нь “Монголын мэдээ” сувгийн (олон нийтийн телевизийн хоёрдугаар суваг) үүрэг байх болно гэж төлөвлөж байжээ. Гэвч энэ туршилт амжилтгүй болж, үзэгчид МҮОНТ-ийн нэгдүгээр сувгаар “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрөө үгүйлж байгаа нь илэрхий болов. Хэдхэн сарын дараа “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрийг “MNB” сувгаар уламжлал болсон 20:00 цагаас дамжуулдаг болсон.

1990-ээд оны эхэн үед "Цагийн хүрд" нэвтрүүлгийг мөн эрэгтэй, эмэгтэй хоёр нэвтрүүлэгч хөтөлдөг байсан. Энэ байдал 1990-ээд оны хоёрдугаар хагасаас өөрчлөгдөж эфирт нэг л нэвтрүүлэгч ажилладаг болов. 2016 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн МҮОНТ-ийн "Цагийн хүрд" мэдээллийн хөтөлбөрт хоёр нэвтрүүлэгч хөтөлдөг боллоо. Ийнхүү үндэсний телевиз хуучин уламжлалаа сэргээжээ.

МҮОНТ-ийн “Монголын Мэдээ” суваг 2017 оны гуравдугаар сарын 13-аас эхлэн 11:00-14:00 цагийн хооронд “Монголын мэдээ” хэмээх хөтөлбөр шууд дамжуулж эхлэв. Энэ хөтөлбөрөөр манай орны улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд өрнөж байгаа үйл явдлыг шууд дамжуулан үзүүлж байна. Мөн манай улсын 21 аймагт суурин ажиллаж байгаа орон нутгийн сурвалжлагч нартайгаа интернетийн сүлжээ-

гээр шууд холбогдож шуурхай сурвалжлага үзүүлэх болов. Өмнө нь хөдөө орон нутагт болж байгаа үйл явдлын тухай мэдээ, сурвалжлагыг хэдэн өдрийн дараа л үзүүлдэг байсан. Харин одоо байдал өөрчлөгдөж аль нэгэн аймгийн төвд болж байгаа нийгмийн ач холбогдол бүхий үйл явдлын тухай мэдээ, сурвалжлагыг цаг алдахгүй үзэх завшаан бүрэлджээ. Улсаа бид зөвхөн Улаанбаатараар төсөөлж, мэдээллийн хөтөлбөрийн агуулгаа төлөвлөх ёсгүй. Хөдөө орон нутгийн тухай мэдээг дамжуулах асуудал дээр “МҮОНТ”-ийн хоёрдугаар суваг “Монголын мэдээ” дэвшил гаргаж чадсан.

11:00-14:00 цагийн хооронд шууд дамжуулдаг “Монголын мэдээ” мэдээллийн хөтөлбөр нь дотоод мэдээ, гадаад мэдээ, спортын мэдээний булантай. Гадаад мэдээний орчуулагч-редакторууд дэлхий дахинд болж байгаа үйл явдлын тухай мэдээг “BBC NEWS”, “EURO NEWS”, “CCTV”, “NHK” гэх мэт гадаадын телевизүүдийн сайтаас нь шууд тоймлон ярьдаг болов. Мөн энэ хөтөлбөрт www.mnb.mn сайтын редактор нь оролцож, сайтдаа нийтлэгдсэн мэдээ, нийтлэлийн тоймыг танилцуулдаг. Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба байрладаг “Хангарьд” цамхагт “Монголын мэдээ” сувгийн хоёрдугаар студи бий. Ажлын өдрүүдэд 11:00-14:00 цагийн хооронд шууд дамжуулдаг “Монголын мэдээ” хөтөл-бөрийн дундуур “Хангарьд” студитэй холбогдож сэтгүүлч Д.Цондовдорж зочинтой шууд ярилцлага өрнүүлдэг. Өдрийн хөтөлбөртэй болсноор оройны “Цагийн хүрд” мэдээллийн хөтөл-бөрөөр үзүүлэх мэдээний тал хувь нь бэлтгэгдэж байна гэсэн үг.

“Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан дохионы хэлээр давхар хүргэдэг. Энэ бол давуу тал юм. МҮОНТ-ийн “ММ” агентлагийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрийн нэг дугаарт ойролцоогоор 14-18 дотоод мэдээ, сурвалжлага, 4-6 гадаа мэдээ сурвалжлага үзүүлдэг. Мөн спортын мэдээний булангаар дунджаар 6-8 мэдээ сурвалжлага үзүүлдэг байна. “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрөөр үзүүлж байгаа нэг сурвалжлагын үргэлжлэх хугацаа дунджаар 2 минут 30 секунд байна. Хамгийн удаан үргэлжилж байгаа сурвалжлага нь 4 минут 37 секунд байлаа. Дэлхийн жишгээр телевизийн мэдээллийн хөтөлбөрт үзүүлж байгаа нэг сурвалжлагын үргэлжилэх хугацаа нь 1 минут 30 секунд байвал тохиромжтой гэж үздэг.

Хагас зуун жилийн туршлагатай ууган телевизийн мэдээллийн хөтөлбөрт давуу тал олон бий. Гэвч аливаа зүйл төгс байдаггүй. Иймд “Цагийг хүрд” мэдээллийн хөтөлбөрт байгаа зарим дутагдлыг сийрүүлье.

“Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөр төр засгийн удирдлагуудын өдөр тутмын ажил, эсвэл үр бүтээлтэй олон жил хөдөлмөрлөсөн хүмүүст төрийн дээд шагнал, одон гардуулсан тухай мэдээ, сурвалжлагыг нэн тэргүүнд дамжуулдаг “уламжлалаа” орхисонгүй. “Цагийн хүрд” шагналын тухай мэдээ, сурвалжлагаар эхлэх нь буруу. Дэлхийн олон улс орны телевизүүд мэдээллийн хөтөлбөрийнхөө эхэнд нийгмийн өмнө тулгарсан цаг үеийн асуудал, зөрчлийн талаар л нэн тэргүүнд мэдээлнэ гэсэн зарчим баримтлан ажилладаг гэдгийг санах хэрэгтэй. Мөн олон нийтийн телевизийн “Цагийн хүрд” мэдээллийн

хөтөлбөрөөр сэдвийн гэхээсээ илүү, үйл явдлын мэдээ, сурвалжлага түлхүү үзүүлдэг.

Мөн зарим мэдээ, сурвалжлагаа хэдэн өдрийн турш давтан үзүүлэх тохиолдол ч гарч байсан. Тухайлбал, 2016 оны хоёрдугаар сарын 8-14-ны өдрүүдэд “Алтан төлийн эзэн” шагнал гардуулсан тухай сурвалжлагыг өдөр алгасалгүй үзүүлэв. Мөн хоёрдугаар сарын 10-нд (лхагва гараг) “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрөөр “Сэлэнгэ аймгаас 3 компани тэргүүний тариаланч хамт олноор тодорлоо” сурвалжлага үзүүлсэн. Хоёрдугаар сарын 12-нд (баасан гараг) “Цагийн хүрд” хөтөлбөрөөр мөнөөх сурвалжлагыг бүрэн эхээр нь давтаж гаргасан юм. Мэдээллийн хөтөлбөр үргэлж шинэ мэдээлэлтэй, шуурхай, цаг үеэ тусгасан байх ёстой гэдэг үндсэн зарчим хэрэгжсэнгүй.

2017 оны хоёрдугаар сарын 13-нд “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрөөр сурвалжлагчийн хэлсэн үг дэлгэцийн доод хэсэгт гарсан тайлбар бичээс (субтитр)зөрөв. “Говьсүмбэр аймгийн мал сүрэг хонин жилд 13.5 хувиар өсч, 38 гаруй мянгад хүрсэн байна” гэж субтитрт бичсэн байсан. Харин мэдээний эхэнд сурвалжлагч “Говьсүмбэр аймгийн мал сүрэг хонин жилд 13.5 хувиар өсөж 380 гаруй мянгад хүрлээ” гэж мэдээлсэн. Ганц тоог л дутуу эсвэл илүү бичихэд маш их тооны зөрүү гарч, том алдаа гарч болдог. Ганц үсэг, тэмдэгтийн алдаа гаргахад л том асуудал гарч болзошгүй. Хэвлэл мэдээллийн байгууллагын нийгмийн өмнө хүлээх хариуцлага өндөр гэдгийг умартаж болохгүй.

“Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрийн гадаад мэдээний булангаар үзүүлж байгаа мэдээний тоо харилцан адилгүй байна. Энэ нь

тухайн өдрийн хөтөлбөрт дотоод мэдээ, сурвалжлага хичнээн орсонгэдгээс шууд хамаарч байна гэсэн өнгөц дүгнэлт хийхэд хүргэж байна. Зарим үед ердөө гурван гадаад мэдээгээр хязгаарлагдсан тохиолдол ч бий. Гадаад мэдээний буланд гардаг түгээмэл алдаа бол тайлбар, дүрс нь зөрөх явдал юм. Жишээ нь, 2017 оны есдүгээр сарын 18-нд Европын холбооны тухай мэдээний тайлбарыг орчуулагч-редактор уншиж байхад дэлгэцээр Японы нийслэл Токио хотын дүрсийг үзүүлэв. Энэ нь найруулагч, гадаад мэдээний орчуулагч редактор нягт хамтран ажиллаж чадахгүй байгаагийн илрэл юм. 2016 оны наймдугаар сарын 4-нд Казахстан улсын нийгмийн асуудлын тухай мэдээний доор “Казахстан улсад өнгөт хувьсгалийн шинж тэмдэг илэрч байна хэмээн Ерөнхийлөгч Нурсултан Назарбаев мэдэглээ” гэсэн титр гаргав. Мэдэгдлээ гэж бичихдээ нэг үсэг гээжээ.

“Цагийн хүрд” хөтөлбөрийг үзүүлж байх үед дэлгэцийн доод хэсэгт “урсдаг мөр” (бегущая строка/ субтитр) гэж мэргэжлийн хүрээнийхэн нэрлэж заншсан мэдээлэл гаргадаг. Дэлгэцийн доод хэсэгт гарч байгаа ганц өгүүлбэр нь үзэгчдэд ойлгомжтой тодорхой мэдээлэл өгч чаддаггүй. 2016 оны дөрөвдүгээр сарын 10-нд дэлгэцийн доод хэсэгт “Шинээр 6 эм нээжээ.” гэдэг өгүүлбэрээр жишээ татаж болно. Нэгдүгээрт, утгын хувьд алдаатай. Эмийг нээдэггүй. Хоёрдугаарт, хаана, ямар өвчнийг анагаах эм шинээр хийсэн нь үзэгчдэд таавар болж байна.

Үг үсгийн болон найруулга зүйн хувьд алдаатай өгүүлбэр зөвхөн субтитрт бус эфирт ч гарч байлаа. Жишээ нь, 2017 оны дөрөвдүгээр сарын 10-ны мэдээллийн хөтөлбөрт

“НӨАТ-ийн 15668 азтан тодорлоо” гэсэн өгүүлбэр гарчээ. НӨАТ гэдэг нь “нэмэгдсэн өртгийн албан татвар” гэдэг нэрийн товчлол. Иймд татварын гэж бичигддэг тул НӨАТ-ын гэж бичих ёстой нь зөв юм.

МҮОНТ-ийн “Монголын мэдээ” агентлагийн мэдээ, мэдээллийн хөтөлбөрт хийсэн ажиглалтын эцэст дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

-Манай улсын ууган телевизийн нэвтрүүлгийн сүлжээнд мэдээ, мэдээллийн хөтөлбөр чухал байр суурь эзэлж ирсэн. Мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийг хийхдээ ЗХУ (хуучин нэрээр)-ын телевизийн туршлагаас жишиг авчээ. Тус телевизийн мэдээллийн нэвтрүүлэг бэлтгэдэг редакци нь нийгэм, цаг үеийн хувьсал өөрчлөлтийн нөлөөгөөр бүтэц зохион байгуулалтын хувьд хэд хэдэн удаа өөрчлөгдсөн байна.

-МҮОНТ-ийн “Монголын мэдээ” агентлаг нь улс оронд болон хилийн чанадад болж байгаа үйл явдал, үзэгдэлийн тухай мэдээг тогтмол цагуудад шуурхай дамжуулж, өмнөө тавьсан зорилгоо тодорхой хэмжээнд гүйцэтгэж байна.

-“Монголын мэдээ” агентлаг нь үйл ажиллагаагаа зөвхөн мэдээ дамжуулах төдийхөнөөр хязгаарлаагүй. Улстөр, нийгэм, эдийн засаг, эрх зүй гээд нийгмийн амьдралын олон талт асуудлыг тусгасан, эрэн сурвалжилсан, асуудал дэвшүүлсэн, хөтөлбөр, нэвтрүүлгийг бэлтгэж байна.

-Цаг үеийн хандлага, орчин үеийн нийгмийн шаардлага, үзэгчдийн мэдээлэл хүлээн авах арга хэрэгсэл өөрчлөгдөж байгаатай уялдуулан “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрийн хэлбэр,

хийц, дотоод бүтэц нь аажмаар хувьсан өнөөгийн өнгө төрхөө олж авчээ.

-“Цагийн хурд” мэдээллийн хөтөлбөрийг бэлтгэдэг баг нь мэргэжлийн байгууллагын хувьд гаргаж болшгүй алдааг гаргаж байгаа нь удаан хугацааны ажиглалтаас харагдаж байна. Иймд редакторуудын ажлын хариуцлагыг дээшлүүлснээр дээрх дутагдлыг хойшид гаргахгүй байх боломжтой юм.

Ишлэл

- ¹В.Л.Цвик Телевизионная журналистика: история, теория, практика. М.,2004.с.292
- ² Наранжаргал Х. Телевизийн сэтгүүл зүй. УБ., 2006. х.123
- ³ Өнөрсайхан Т. Телевизийн оргил цагийн нэвтрүүлгийн агуулгын зарим онцлогийн тухайд. МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг “Сэтгүүл зүй”. 2013 №14(393) х.65
- ⁴ Мэндхүү Г., Өнөрсайхан Т. Телевизийн тухай А-Я хүртэл. УБ., 2014. х.65
- ⁵Өнөрсайхан Т. Арилжааны телевизүүдийн нэвтрүүлгийн сүлжээний онцлог, тулгамдсан асуудал. МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг “Сэтгүүл зүй” 2014 №15 (417) х.210
- ⁶ Мэндхүү Г., Өнөрсайхан Т. Телевизийн тухай А-Я хүртэл. УБ., 2014. х.65
- ⁷ Наранжаргал Х. Телевизийн сэтгүүл зүй.УБ.,2006. х.123
- ⁸ Г.Бадамсамбуу: Аглаг ойд номоо бичээд л амьдрах юм сан <http://www.assa.mn/content/2167.shtml?a=art> 2012.05.01
- ⁹ Норовсүрэн Л. Ариунзаяа Н. Телевизийн сэтгүүл зүй. УБ.,2009. х.16

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Мэндхүү Г., Өнөрсайхан Т. 2014. Телевизийн тухай А-Я хүртэл. УБ.
2. Наранжаргал Х. 2006. Телевизийн сэтгүүл зүй. УБ.
3. Норовсүрэн Л, Ариунзаяа Н. 2009.Телевизийн сэтгүүл зүй. УБ.
4. Өнөрсайхан Т. Телевизийн оргил цагийн нэвтрүүлгийн агуулгын зарим онцлогийн тухайд // МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг “Сэтгүүл зүй”. 2013. №14(393)
5. Өнөрсайхан Т. Арилжааны телевизүүдийн нэвтрүүлгийн сүлжээний онцлог, тулгамдсан асуудал. // МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг “Сэтгүүл зүй” 2014 №15 (417)
6. В.Л.Цвик Телевизионная журналистика: история, теория, практика. М.,2004.С.292
7. www.mnb.mn
8. <http://www.assa.mn/content/2167.shtml?a=art> 2012.05.01

Резюме

Автор рассматривает процесс становления и развития новостных программ Общественного телевидения Монголии. В статье дается характеристика информационной программы “Цагийн хурд” (Колесо времени) и автор причисляет некоторые ошибки допущенные творческой коллегой. Опираясь на конкретные примеры, автор классифицировал эти ошибки и выявил причину.